ВИДЕО МЭДЭЭ · 2022 оны 9-р сарын 16

Про подкаст №94 БАЙГАЛИЙН УРГАМЛЫГ ХУУЛЬ БУСААР БЭЛТГЭХ ГЭМТ ХЭРГИЙН ТАЛААР



УЕПГ-ын Олон нийттэй харилцах албаны мэргэжилтэн Б.Будхүү Завхан аймгийн прокурорын газрын хяналтын прокурор Н.Баасанжавтай "Байгалийн ургамлыг хууль бусаар бэлтгэх гэмт хэргийн талаар" сэдвээр ярилцлаа.

• Хонин арц гэж ямар ургамал вэ?

• Хонин арц нь Монгол Улсын хэмжээнд устаж үгүй болж болзошгүй ургамлын төрөл зүйлд багтдаг учир Байгалийн ургамлын тухай хуульд хонин арцыг нэн ховор ургамлын жагсаалтад оруулж хуульчилсан байдаг.

• Байгалийн ургамлыг хууль бусаар бэлтгэх гэмт хэрэгт ямар хариуцлага оногдуулах вэ?

• Байгалийн ургамлыг хууль бусаар бэлтгэсэн бол 5.400.000-27.000.000 төгрөгөөр торгох, 1-5 жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл 1-5 жил хүртэл хугацаагаар хорих ялаар шийтгэнэ.

• Байгаль орчныг хамгаалах тухай хуульд заасны дагуу байгаль орчинд учирсан хохирлын хэмжээг 5 дахин нэмэгдүүлэн нөхөн төлүүлж, гэмт хэрэг үйлдэж олсон

орлого болох түүсэн арц, гэмт хэрэг үйлдэхдээ ашигласан тээврийн хэрэгслийг тус тус улсын улсын орлого болгодог хуулийн зохицуулалттай.

• Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээг тогтоохдоо Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2020 оны А/677 дугаар тушаалыг баримталж, 1 кг-ыг нь 100.900 /нэг зуун мянга есөн зуу/ төгрөгөөр тооцдог.

Видео: https://www.youtube.com/watch?v=d0xwdpu_YP0

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/1927